

## **Монгол улсын Ардын эмч, гавъяат эмч Б.Үйлстийн нэрэмжит оны шилдэг эмч шалгаруулах МЭБЭЭНХ-ны болзол**

2019 оны 11 дүгээр сарын 4

**Зорилго:** Төв, хөдөөгийн эмнэлгүүдэд ажиллаж буй эх барих, эмэгтэйчүүдийн эмч нарын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг сайжруулж, тэдний идэвх санаачлагыг дээшлүүлэх, эмчилгээ оношлогооны дэвшилтэт арга, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой.

### **Шалгаруулах болзол:**

1. Мэргэжил мэдлэгээ байнга дээшлүүлж, эмчийн зэрэг хамгаалсан байх
2. Мэргэжлээрээ тогтвортой, үр бүтээлтэй ажиллаж, удирдлага болон үйлчлүүлэгчдийн талархалыг хүлээсэн, ёс зүйн алдаа гаргаагүй байх
3. Эмч нарт хичээл заах, дагалдуулан сургах зэргээр бусад эмч мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадварыг сайжруулахад хувь нэмэр оруулсан байх
4. Сүүлийн 3 жилд эмчилгээ, оношлогоонд дэвшилтэт арга, тэргүүн туршлага нэвтрүүлсэн байдал
5. Сүүлийн 3 жилд мэргэжлийн зөвлөмж, зөвлөгөө, удирдамж боловсруулж, ажилдаа ашигласан байдал
6. МЭБЭЭНХ болон салбар зөвлөлийн ажилд идэвх санаачлагатай оролцсон байдал

### **Ирүүлэх материал:**

1. Шагналд нэр дэвшигчийн товч анкет
2. Сүүлийн 3 жилээр дээрх болзолуудын талаар хийсэн ажлыг тусгасан тайлан
3. Салбар зөвлөлийн хурлын тэмдэглэл
4. Албан байгууллагын даргын тодорхойлолт

### **Шалгаруулалт:**

Шилдэг эмчийн шагнал олгох Б.Үйлст болон МЭБЭЭНХ-ны ажлын хэсэг ирүүлсэн материалуудыг үндэслэн шилдэг эмчийг шалгаруулж, Удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлнэ.

МЭБЭЭНХ